**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 30 өдөр                    Дугаар А/596                    Номгон

Татварын орлого хураалтыг эрчимжүүлэх
аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 заалт, аймгийн төсвийн орлого 2023 оны жилийн эцэс, 2024 оны 9 дүгээр сарын гүйцэтгэлээр нэр төрлөөрөө тасарсан, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт хангалтгүй байгаа зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг нэр төрөл тус бүрээр хангах биелүүлэх зорилгоор “Татварын орлого хураалтыг эрчимжүүлэх аян”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2.“Татварын орлого хураалтыг эрчимжүүлэх” аяныг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Аяныг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг 2024 оны 12 дугаар сарын эхний долоо хоногт багтаан удирдлагын зөвлөлд танилцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Д.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА                                        Д.МӨНХСАЙХАН

624211511